

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2021 оны 9-р сарын 30

дугаар 01

Улаанбаатар хот

Компанийн өрийг хувьцаагаар солих,
түүнтэй холбоотой хувьцаа нэмж гаргах тухай


Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 61.1.3, тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Өрийг хувьцаагаар солих зорилгоор 2,253,583 ширхэг энгийн хувьцаа нэмж гаргасугай.
2. Өрийг хувьцаагаар солих зорилгоор нэмж гаргасан хувьцааны нэгжийн үнэ буюу өрөндөө тооцуулах хувьцааны үнийг 2021 оны 09 дүгээр сарын 14-ний өдрөөр тасалбар болгосон хувьцааны сүүлийн 6 сарын дундаж жигнэсэн ханшийг үндэслэн гаргасан 1013 төгрөгөөр тогтоосугай.
3. “Хай Би Ойл ХК”-д төлөх 2,282,879,529 төгрөгийн өрийг нэмж гаргаж буй 2,253,583 ширхэг энгийн хувьцаагаар сольсугай.
4. Өрийг хувьцаагаар сольж буйтай холбогдуулан өрийг хувьцаагаар солих төслийг тогтоолын хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА _____ Г.ХУЛАН



“Шарын Гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын
2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн
Ээлжит бус хурлын ~~27~~ тогтоолын хавсралт



“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХ ТӨСӨЛ

НЭГ. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү компанийн өрийг хувьцаагаар солих төсөл (цаашид “төсөл” гэх) -ийн зорилго нь “Шарын Гол” ХК (цаашид “Компани” гэх) -ийн өрийг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “СЗХ” гэх) -ны Үнэт цаасны бүртгэлийн журам, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК (цаашид “МХБ” гэх) -ийн Үнэт цаасны бүртгэлийн журам, бусад холбогдох журамд заасны дагуу Компанийн хувьцаанд хөрвүүлэх, түүнтэй холбогдон хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргах, СЗХ болон МХБ-ийн үнэт цаасны бүрдүүлбэрт холбогдох өөрчлөлтийг оруулах, өрийг хувьцаагаар солихтой холбогдон үүсэх хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2 Оролцогч талуудын мэдээлэл
Зээлдэгч: “Шарын гол” ХК
Зээлдэгчийн улсын бүртгэлийн дугаар: 1910010009
Зээлдэгчийн хаяг: Монгол Улс, Дархан-Уул аймаг, Шарын гол сум, Санжинт 3-р баг, “Шарын Гол” ХК-ийн байр
Зээлдүүлэгч: “Хай Би Ойл” ХК
Зээлдүүлэгчийн улсын бүртгэлийн дугаар: 9010001063
Зээлдүүлэгчийн хаяг: Монгол Улс, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, Сонсголон, 110 тоот
- 1.3 Өрийг хувьцаагаар солих үндэслэл
Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйл болон 63.7-д Компанийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын дийлэнх олонхын саналаар өрийг хувьцаагаар солих тухай шийдвэрлэнэ хэмээн заасан нь Компанийн өрийг хувьцаагаар солих эрх зүйн үндэслэл болно.

ХОЁР. Өрийн тухай мэдээлэл, зээлийн зарцуулалт

- 2.1 Өрийн тухай мэдээлэл
Компани нь 2014 оны 07 сарын 30-ны өдөр “Хай Би Ойл” ХК (цаашид “Зээлдүүлэгч” гэх)-тай зээлийн гэрээ байгуулан 500,000 ам.долларыг 6.0 хувийн хүүтэй, 3 сарын хугацаатай зээлсэн. Үүнээс 85,500 ам.долларыг гэрээний хугацааны дагуу эргэн төлсөн ба үлдэгдэл төлбөрийг зээлийн гэрээнд нийт 3 удаа нэмэлт өөрчлөлт оруулан зээлийн хугацааг 2016 оны 12 сарын 31-ны өдөр хүртэл сунгасан.

2015 оны 07 сарын 01-ны өдөр Компани нь Зээлдүүлэгчтэй дахин зээлийн гэрээ байгуулан 6.0 хувийн хүүтэй, 12 сарын хугацаатай 250,000 ам.долларыг зээлсэн. 2016 оны 07 сарын 25-ны өдөр уг гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан гэрээний хугацааг 2017 оны 06 сарын 30-ны өдөр хүртэл сунгасан.

Компани нь Зээлдүүлэгчтэй 2 удаа зээлийн гэрээ байгуулан нийт 750,000 ам.долларыг зээлсэн ба үүнээс 664,500 ам.долларын үндсэн төлбөрийн үлдэгдэлтэй байна. Уг үндсэн төлбөрт 2019 оны 12 сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон 170,642.79 ам.долларын зээлийн хүүгийн төлбөрийн өр хуримтлагдсан ба Компани нь нийт 835,142.79 ам.доллар буюу тасалбар болгосон өдрийн Монголбанкнаас зарласан (1 доллар тэнцүү 2,733 төгрөг) ханшаар тооцсон 2,282,879,519.32 төгрөгийн өртэй байна.

2.2 Өр үүссэн шалтгаан:

Компани нь бизнес төлөвлөгөөний дагуу компанийн өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор 2014 оны 07 сарын 30-ны өдөр Зээлдүүлэгчтэй зээлийн гэрээ байгуулан 500,000 ам.долларыг зээлсэн.

2015 оны 07 сарын 1-ны өдөр Компани нь “Могоул Паур” ХХК-аас авсан зээлийг эргэн төлөх зорилгоор Зээлдүүлэгчтэй дахин зээлийн гэрээ байгуулан 250,000 ам.долларыг зээлсэн.

2.3 Зээлийн зарцуулалт:

Компани нь 2014 оны 07 сарын 30-ны өдөр байгуулсан зээлийн гэрээний дагуу зээлийн эхний хэсэг болох 300,000 ам.долларыг 2014 оны 07 сарын 31-ны өдөр, үлдсэн 200,000 ам.долларыг 2014 оны 09 сарын 29-ны өдөр хүлээн авсан.

Зээлийн зарцуулалтыг дор жагсаав.

Зарцуулалт	Мөнгөн дүн (ам.доллар)	Мөнгөн дүн (төгрөг)
Зээл	500,000	928,868,000
Ажилчдын цалин, хөлс		366,492,586
Шатахуун		200,000,000
Харуул хамгаалалт		105,200,000
Сэлбэг, материал		83,115,360
Хайгуул		70,000,000
Татвар		40,000,000
Тос		29,480,080
Тээлгээ		20,000,000
Даатгал		12,272,460
Бусад		2,307,514
Бүгд		928,868,000

Компани нь Зээлдүүлэгчтэй 2015 оны 07 сарын 01-ны өдөр дахин зээлийн гэрээ байгуулан 250,000 ам.долларыг зээлсэн ба уг зээлийг “Могоул Паур” ХХК-аас авсан зээлийг эргэн төлөхөд бүрэн ашигласан.

ГУРАВ. Өрийг хувьцаагаар солих шаардлага, нөхцөл

3.1 Өрийг хувьцаагаар солих шаардлага

Компанийн 2021 оны эхний хагас жилийн тайланд тусгагдсанаар Компани нь 78.2 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй ба үүнээс эздийн өмч 19.4 тэрбум төгрөгийг, нийт өр төлбөр 58.7 тэрбум төгрөгийг эзэлж өр төлбөр, эздийн өмчийн харьцаа 302% байна. Нийт өр төлбөрийн 27.3 тэрбум төгрөгийг урт хугацаат өр төлбөр бүрдүүлж байгаа ба үлдсэн 31.4 тэрбум төгрөгийг эргэлтийн өр төлбөр бүрдүүлж байна. 2021 оны хагас жилийн байдлаар Компанийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 2.2 тэрбум

төгрөг, нийт эргэлтийн хөрөнгийн дүн 13.8 тэрбум төгрөг байгаа нь компани богино хугацаат өр төлбөрөө барагдуулах чадвар бага, өрийн дарамттай байгааг илэрхийлж байна. Иймээс Компани нь зээлийн хэмжээг бууруулах, өрийн дарамтыг багасгах зорилт тавин ажиллаж байгаа ба үүний нэг хэсэг нь Компанийн өрийг хувьцаагаар солих явдал юм.

Үзүүлэлт /мянган төгрөг/	2020	2021-II
Нийт хөрөнгө	83,736,965	78,254,431
Эздийн өмч	19,799,587	19,465,121
Нийт өр төлбөр	63,937,378	58,789,309
Өр төлбөр эздийн өмчийн харьцаа	323%	302%
Урт хугацаат өр төлбөр	27,891,387	27,327,991
Богино хугацаат өр төлбөр	36,045,991	31,461,317
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,400,271	2,258,916
Нийт эргэлтийн хөрөнгө	15,071,705	13,807,186

3.2 Орийг хувьцаагаар солих нэгж хувьцааны үнэ тогтоосон үндэслэл

Монголын хөрөнгийн биржээс 2021 оны 09 сарын 14-ний өдөр ирүүлсэн 03/378 тоот албан бичигт дурдсанаар Компанийн үнэт цаасны 2021 оны 09 сарын 14-ны өдрөөр тасалбар болгосон 6 сарын жигнэсэн дундаж ханш 1,013 төгрөг байсан ба уг ханшид үндэслэн өрийг хувьцаанд хөрвүүлэх нэгж хувьцааны ханшийг 1,013 төгрөгөөр тогтоосон.

Хувьцааны үнийн мэдээлэл

Үзүүлэлт	Үнэ
Хаалтын ханш (2021.09.21)	1,000.00
6 сарын жигнэсэн дундаж ханш (2021.09.14)	1,013.00
Дансны үнэ (2021.07.20)	1,913.92
Шинээр нэмж гаргах хувьцааны үнэ	1,013.00

3.3 Өрийг хувьцаагаар солихоор шинээр нэмж гаргах хувьцааны тоо

Компанийн өрийг хувьцаагаар сольсноор Компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2,253,583 ширхэг хувьцааг нэмж гаргаж Зээлдүүлэгчид эзэмшүүлнэ. Ингэснээр Компани нь нийт 12,423,825 ширхэг энгийн хувьцаатай, 1,242,382,500 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болно.

Зээлийн болон шинээр нэмж гаргах хувьцааны мэдээлэл:

Үзүүлэлт	Дүн
Зээлийн үндсэн төлбөрийн дүн (ам.доллар)	664,500
Зээлийн хүүгийн төлбөрийн дүн (ам.доллар)	170,642.79
Нийт өр (ам.доллар)	835,142.79
Нийт өр (төгрөг)	2,282,879,519.32
Шинээр нэмж гаргах нэгж хувьцааны үнэ (төгрөг)	1,013
Шинээр нэмж гаргах хувьцааны тоо	2,253,583

Өрийг хувьцаагаар сольж, Зээлдүүлэгчид 2,253,583 ширхэг хувьцааг эзэмшүүлснээр Зээлдүүлэгч нь Компанийн нийт гаргасан хувьцааны 18.13%-ийг эзэмшинэ.

Компанийн хувьцааны мэдээлэл

Үзүүлэлт	Дүн
Өрийг хувьцаагаар солихоос өмнөх хувьцааны тоо	10,170,242
Шинээр нэмж гаргах хувьцааны тоо	2,253,583
Шинээр нэмж гаргах хувьцааны хувь	18.13%
Өрийг хувьцаагаар сольсны дараах хувьцааны тоо	12,423,825

3.4 Компанийн эздийн өмчид орох өөрчлөлт

Компанийн өрийг хувьцаагаар сольсноор Компанийн нийт өр төлбөрийн дүн 2,282,879,519.32 төгрөгөөр буурч, эздийн өмчийн дүн уг хэмжээгээр нэмэгдэнэ.

Үзүүлэлт	Өрийг хувьцаагаар солихоос өмнө	Өрийг хувьцаагаар сольсны дараа
Гаргасан хувьцааны тоо	10,170,242	12,423,825
Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн (мянган төгрөг)	1,017,024	1,242,382
Нэмж төлөгдсөн капиталын дүн (мянган төгрөг)	11,568,310	12,461,096
Эздийн өмчийн дүн (мянган төгрөг)	19,465,121	21,748,001
Нэгж хувьцааны дансны үнэ	1,913.92	1,750.50

3.5 Өмнөх хувьцаа эзэмшигчдийн эзэмшлийн хувь буурах хувь

Компани өрийг хувьцаагаар солих зорилгоор шинээр хувьцаа нэмж гаргаснаар Компанид хувь эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийн хувьцааны эзэмшлийн хувь буурна. Компани нь нийт хувьцааны 18.13%-тай тэнцэх 2,253,583 ширхэг хувьцааг нэмж гаргаснаар хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны эзэмшлийн хувь нь 18.13% коэффициентоор буурна.

3.6 Нэмж хувьцаа гаргасны дараах хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Компани нь өрийг хувьцаагаар сольж, шинээр хувьцаа гаргасны дараа нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн тоо 7 болж өснө. Эдгээр хувьцаа эзэмшигчид нь компанийн нийт хувьцааны 90.27%-ийг бүрдүүлэхээр байна.

Хувьцаа эзэмшигчид	Хувь	Тоо
Эс Эйч Жи Холдингс 2 С.а.р.л.	16.33%	2,028,906
Эс Эйч Жи Холдингс 3 С.а.р.л.	16.19%	2,011,744
Нихан Холдингс С.а.р.л.	12.87%	1,598,889
Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк	9.32%	1,158,520
Эс Эйч Жи Холдингс 1 С.а.р.л.	9.19%	1,142,674
Хай Би Ойл ХК	18.13%	2,253,583
Тоголдөр мегаминкс ХХК.	8.20%	1,019,550
Бусад	9.73%	1,209,959
Нийт	100.00%	12,423,825

3.7 Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах

Компанийн өрийг хувьцаагаар солих асуудлаар компанийн дүрэмд өөрчлөлт оруулж компанийн зарласан хувьцааны тоог 2,253,583 ширхгээр нэмэгдүүлэн 12,423,825 болгоно. Энэхүү Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудал нь Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудлуудын жагсаалтад багтсан болно.

ДӨРӨВ. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах, төсөл хэрэгжүүлэх

- 4.1 Компанийн тухай хуулийн 25.3 дах зүйл, компанийн дүрмийн 7.8.3-д заасны дагуу Компанийн өрийг хувьцаагаар солих асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 4.2 Компанийн өрийг хувьцаагаар солих асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх “Шарын Гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн ТУЗ-ийн 2021 оны 08 сарын 20-ны өдрийн хурлын 15 тоот тогтоолын дагуу 2021 оны 09 сарын 30-ны өдрийн 13 цагаас Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж Пиэрл Тауэр 9 давхар 2 тоотод хуралдана.
- 4.3 ХЭХ-ын талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, хурлын материалыг бэлтгэж тараах, хурлыг хуралдуулж шийдвэр гаргуулах, гарсан шийдвэрийг холбогдох байгууллагуудад мэдэгдэх, цахимаар мэдээлэх ажлыг Компанийн тухай хууль, Компанийн дүрэм болон бусад холбогдох хууль, журамд нийцүүлэн гүйцэтгэх үүргийг ТУЗ-өөс томилогдсон хурал зохион байгуулах комисс /цаашид “ХЗБКомисс” гэх/ хэрэгжүүлнэ.
- 4.4 Компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу саналын эрхтэй нийт хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид хуралд оролцоноор хурал хүчин төгөлдөр болно.
- 4.5 Компанийн тухай хуулийн 25.3, 63.7-д заасны дагуу компанийн өрийг хувьцаагаар солих асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.
- 4.6 СЗХ-оос хаалттай хүрээнд нэмж хувьцаа гарган Компанийн өрийг хувьцаагаар солихыг зөвшөөрсөн шийдвэр гарсан өдрөөс эхлэн төсөл бүрэн хэрэгжиж, компанийн хувьцааны бүртгэл, үнэт цаасны бүрдүүлбэр, дүрэмд орсон өөрчлөлтүүдийг холбогдох төрийн захиргааны байгууллагуудад зохих журмын дагуу бүртгүүлснээр Компанийн өрийг хувьцаагаар солих ажиллагаа дуусгавар болно.

ТАВ. Өрийг хувьцаагаар солихтой холбогдон үүсэх хувьцаа эзэмшигчдийн эрх, түүнийг хэрэгжүүлэх журам

- 5.1 Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрх
Компанийн тухай хуулийн 38.8-д заасны дагуу хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэхийг шийднэ. Уг эрхийг эдлүүлэхээр шийдвэрлэвэл дараах журмын дагуу хувьцаа эзэмшигч нь эрхээ эдэлнэ.
 - 5.1.1 Хувьцаа эзэмшигч нь компаниас нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн 5.1.3-д заасан нөхцөлийн дагуу тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй.
 - 5.1.2 Компанийн тухай хуулийн 38.2-т заасан хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх тодорхой нөхцлийг дурдсан мэдэгдлийг хурлын зар хүргэх журмын дагуу нийтэд мэдээлнэ.
 - 5.1.3 Дараах тохиолдолд эрхээ хэрэгжүүлсэнд тооцно.
2021 оны 11 дугаар сарын 11-ны дотор өөрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн хувьцааг сүүлийн 6 сарын дундаж ханш буюу 1,013 төгрөгөөр тооцож хувьцааны үнийг Андеррайтер “Өлзий энд Ко капитал ҮЦК” ХХК -ийн Голомт банкн дах 1103022310 тоот дансанд төлнө. Өөрийн иргэний үнэмлэхний хуулбар,

худалдан авах хувьцааны тоог төлбөрийн баримтын хамт Андеррайтерийн компанид ирүүлнэ.

Андеррайтерийн компанийн хаяг: СБД, 8 хороо, Сити тауэр 2506 тоот
Холбоо барих: 88116377, baуaгmaа@uce.mn

- 5.1.4 Хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 38.1-д заасан эрхээ хууль тогтоомжийн дагуу бүхэлд нь буюу хэсэгчлэн хэрэгжүүлж болно.
- 5.1.4 Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 38.1-д заасан эрхээ хууль тогтоомжийн дагуу бусад этгээдэд бүхэлд нь буюу хэсэгчлэн шилжүүлж болно. Ингэхдээ хувьцаа худалдан авах эрхийг шилжүүлж буй тал болон шилжүүлэн авч буй талууд гэрээ хийж, нотариатаар баталгаажуулна. Эрхийг шилжүүлэн авсан тал энэхүү төслийн 5.1.3-д заасны дагуу холбогдох баримт бичгийг Андеррайтерийн компанид ирүүлнэ.
- 5.2 Эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх
Компанийн тухай хуулийн 53.1-д хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх үүсэх асуудлуудыг дурдсан байдаг. Компани өөрийн нийт хувьцааны 18.13%-тай тэнцэх хэмжээний хувьцааг шинээр нэмж гаргаж байгаа нь уг заалтад тусгагдсан их хэмжээний хэлцлийн дүнд хүрэхгүй тул хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх үүсэхгүй.

---o0o---

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2021 оны 9-р сарын 30

дугаар 02

Улаанбаатар хот

**Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрмийн 4.2 дахь заалтын “Компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 10.170.242 (Арван сая нэг зуун далан мянга хоёр зуун дөчин хоёр) ширхэг энгийн хувьцаа (цаашид “Хувьцаа” гэх) гаргах эрхтэй. Энэ хэмжээнд өөрчлөлт оруулах асуудлыг зөвхөн ХЭ-ийн хурлаар шийдвэрлэнэ” гэснийг “Компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 12.423.825 (Арван хоёр сая дөрвөн зуун хорин гурван мянга найман зуун хорин тав) ширхэг энгийн хувьцаа (цаашид “Хувьцаа” гэх) гаргах эрхтэй. Энэ хэмжээнд өөрчлөлт оруулах асуудлыг зөвхөн ХЭ-ийн хурлаар шийдвэрлэнэ” гэж өөрчилсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ХУЛАН

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2021 оны 9-р сарын 30

дугаар 03

Улаанбаатар хот

Нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид
худалдан авах давуу эрхээ хувьцаа
эзэмшигч хэрэгжүүлэх эсэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.8 дахь хэсэг, тооллогын комиссын
тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах давуу
эрхийг хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхээр шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ХУЛАН

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2021 оны 9-р сарын 30

дугаар 04

Улаанбаатар хот

Тогтоол хүчингүй болсонд
тооцох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь хэсэг, тооллогын комиссын тогтоолыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Шарын гол” ХК-ийн 2021 оны 9-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 01, 02, 03 дугаар тогтоолууд гарсантай холбогдуулан, 2019 оны 4-р сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 03, 04, 05 дугаартай тогтоолуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ХУЛАН